



Abingdon бага сургуулийн сургачийн ар гэрийнхэн танаа:

АНС нь элсэлт багтаамжаас хэтэрч байгаа болон/эсвэл сүүлийн хоёр хичээлийн жилд элсэлт багтаамжаас хэтэрч байсан эсвэл багтаамж дүүрч байсан, ойрын сургууль нь нэмэлт сургач авах багтаамжтай сургуулиудад 2021 оны Намрын улиралд харьялал зохицуулах ажиллагааг хийж байна.

Энэхүү захидлыг хүүхэд нь Abingdon бага сургуулийн 4-р ангид сурдаг бөгөөд харьялал дахин хуваарилах төлөвлөгөөнд багтсан хэсэгт амьдардаг сургачдын ар гэрийнхэнд зориулав. Цэцэрлэгийн өмнөхөөс-3-р ангийн сургачдын ар гэрийнхэнд өөр захидал явуулна.

АНС нь дараах [төлөвлөлтийн хэсгүүдийг](#) Abingdon бага сургуулиас Dr. Charles R. Drew бага сургуульруу хуваарилахаар төлөвлөж байна: 36060, 36061, 36090, 37070, 37100, 37101, 37102. Энэхүү өөрчлөлт нь 2022-23 оны хичээлийн жилээс хэрэгжиж эхлэнэ. Харьяаллын дахин төлөвлөлт нь цэцэрлэгийн өмнөхөөс 4-р ангид сурдаг, дээрх хэсэгт амьдардаг бүх одоо сурч буй сургач болон элсэн орох сургачдад хамаарна.

Бид дараах шалтгаанаар таньтай холбоо барьж байна:

- Төлөвлөж буй өөрчлөлтүүдийн талаар танд мэдэгдэх;
- Тус төлөвлөгөөний талаар нэмэлт мэдээлэл авах болон асуулт асуух уулзалтын талаарх мэдээллийг өгөх;
- Сургуулийн Зөвлөлийн шийдвэрийн хуваарийг танилцуулах; болон
- Танаар Урьдчилсан шийдвэрийн маягт бөглүүлэх. Холбоос бүхий имэйлийг тусад нь явуулах ба цаасан хуулбарыг Abingdon сургуулийн төв оффисоос авах боломжтой.

Урьдчилсан шийдвэрийн маягтын (Letter of intent form) зорилго нь энэхүү харьяаллын дахин төлөвлөлтийн талаарх мэдээллийг таныг авсан болохыг баталгаажуулан та хүүхдээ 2022-23 оны хичээлийн жилд 5-р ангид ороход нь Abingdon сургуульд үргэлжлүүлэн суралцуулах уу эсвэл Dr. Charles R. Drew бага сургуульд явуулж эхлэхээр төлөвлөж байгаа юу гэдгийг мэдэх явдал юм.

#### **Чөлөөлөгдөх эрх, Шинэ сургач, Ах эгч дүү, Тээврийн мэдээлэл**

- **Чөлөөлөгдөх:** Одоо 4-р ангид сурч буй, 2022-23 оны хичээлийн жилд 5-р ангид орох сургачдад энэхүү дахин төлөвлөлтөөс чөлөөлөгдөн Abingdon сургуульдаа үргэлжлүүлэн суралцах боломжийг олгох саналыг АНС-н ажилтнууд гаргаж байгаа. Дахин төлөвлөлтөөс чөлөөлөгдөн Abingdon сургуульд үлдэн суралцах эрхтэй сургачдад 2022-2023 оны хичээлийн жилд Dr. Charles R. Drew сургуульд суралцах эрх олгогдоно.
- **Шинэ сургачид:** Дахин төлөвлөлтөнд багтсан хэсэгт амьдардаг, 2022 оны 6-р сарын 17-оос хойш АНС-д элсэн орох сургач Dr. Charles R. Drew бага сургуульд суралцана.
- **Ах эгч дүү:** Одоо Abingdon сургуулийн 4-р ангид сурдаг сургачийн ах эгч дүүг 2022-23 оны хичээлийн жилд Abingdon-д үлдэн суралцах боломжоор олгох эсэх дээр шийдвэр гаргахын тулд АНС нь сургачдын ар гэрийнхнээс мэдээлэл цуглуулж байна. 2023-24 оны хичээлийн

жил эхлэхэд тухайн ах эгч дүү нь Dr. Charles R. Drew бага сургуульд суралцаж эхлэх болохыг анхаарна уу.

- **Тээвэр:** Дахин төлөвлөлтөөс чөлөөлөгдөн 2022-23 оны хичээлийн жилд Abingdon-д үлдэн суралцахаар болсон сурагчдад АНС-н тээврийн үйлчилгээг автобусны [хаб зогсоолоор](#) дамжуулан олгоно. Ах эгч дүүгийн тээврийн мэдээллийг 11-р сарын дундаас олгоно.

#### Ар гэрийнхэнтэй уулзах хуваарь

Ар гэрийнхэнтэй виртуал уулзалт хийх хуваарь		
	Огноо	Цаг
Уулзалт 1	2021 оны 10-р сарын 16	11:45 a.m. – 12:30 p.m.
Уулзалт 2	2021 оны 10-р сарын 19	12:45 p.m. – 1:30 p.m.
Уулзалт 3 (Зөвхөн Испани хэлээр, Англи хэл байхгүй)	2021 оны 10-р сарын 20	7:45 p.m. – 8:30 p.m.
Уулзалт 4	2021 оны 10-р сарын 21	7:45 p.m. – 8:30 p.m.

#### Ар гэрийнхэнтэй хийх виртуал уулзалтын талаарх мэдээлэл

- Эдгээр уулзалтын холбоосыг дараах хаягнаас авна уу <https://www.apsva.us/engage/fall-2021-boundary-process/>.
- Уулзалт дууссаны дараа бичлэгийг нь онлайнаар тавина.
- Ар гэрийнхэнтэй хийх виртуал уулзалт бүр дээр нэг ижил мэдээлэл хүргэнэ.
- Хурал дээр Амхарик, Араб, Монгол, Испани хэлээр хэлмэрчлэнэ.

Виртуал Ажлын Цагийн Хуваарь	
Огноо	Цаг
2021 оны 10-р сарын 26	7:30 p.m. – 8:00 p.m.
2021 оны 10-р сарын 28	12:30 p.m. – 1:00 p.m.

#### Виртуал Ажлын Цагийн Мэдээлэл

- Ажлын цагаар ар гэрийнхэн асуулт асуувал асуултанд даруй хариулна.
- Уулзалтын үеэр асуусан зарим асуултын хариултыг Нийтлэг асуудаг асуулт болгон онлайн дээр тавьж болно.
- Энэ хоёр ажлын цагийн уулзалтын үеэр Испани хэл дээр хэлмэрч ажиллана.

Харьяаллын дахин төлөвлөлтийн цагийн хуваарь	
Огноо	Үйл ажиллагаа
2021 оны 10-р сарын 15-31	Ар гэрийнхэнтэй уулзах
2021 оны 11-р сарын 16	Суперинтендентийн харьяаллын дахин төлөвлөлтийн саналыг Сургуулийн Зөвлөлд танилцуулна
2021 оны 11-р сарын 30	Харьяаллын дахин төлөвлөлтийн талаар Сургуулийн Зөвлөл нээлттэй хуралдана
2021 оны 12-р сарын 2	Суперинтендентийн харьяаллын дахин төлөвлөлтийн саналын талаар Сургуулийн Зөвлөл Шийдвэр гаргана

2021 оны Намрын Харьяаллын дахин төлөвлөлтийн үйл явцын талаарх мэдээллийг [www.apsva.us/engage/fall-2021-boundary-process](http://www.apsva.us/engage/fall-2021-boundary-process) хаягаар авна уу. Нэмэлт мэдээлэл, асуулт байвал [engage@apsva.us](mailto:engage@apsva.us) хаягаар имэйл бичнэ үү.

Хүндэтгэсэн,

Лиса Стенгле  
Гүйцэтгэх Захирал  
Арлингтон Нийтийн Сургуулиуд